



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2020 оны 07 сарын 28 өдөр

Дугаар 409

Улаанбаатар хот

Удирдамж болгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 21 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1.“Сэлэнгэ АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд төрийн өмчийн төлөөлөл хэрэгжүүлж буй гишүүдэд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг удирдамж болгосугай:

1.1.“Сэлэнгэ АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Лхагважавын Ганболдыг өөрийн хүсэлтээр үүрэгт ажлаас нь чөлөөлж, түүнтэй байгуулсан контрактыг 2020 оны 07 дугаар сарын 28-ны өдрөөр тасалбар болгон холбогдох хууль тогтоомжийн дагуу цуцлах;

1.2.“Сэлэнгэ АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирлыг томилогдолтой захирлын албан үүргийг ерөнхий инженер Намсрайн Пүрэвсүрэнгээр түр хавсран гүйцэтгүүлэх.

2.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГА 
Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН
ДАРГА  Ц.БАЯР-ЭРДЭНЭ

000761